

I-V/2021

Тархаасан: 2021 оны 6 дугаар сарын 14




Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар, зарлага 13.7 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 5 сард 1252.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 172.9 (16.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 172.9 тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 172.2 (22.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөн 2021 оны 5 дугаар сард нийгмийн даатгалын сангийн орлого 254.0 тэрбум төгрөг, зарлага 281.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас орлого 24.6 (10.7%) тэрбум төгрөгөөр, зарлага 13.2 (4.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Нийгмийн даатгалын сангийн зарлага 2021 оны эхний 5 сард 1301.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 156.9 (13.7%) тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 65.8(7.5%) тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 92.1 (3.7 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2021 оны эхний 5 сард 10246 хүнд 22.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 870 (9.3%) хүнээр нэмэгдэж, олгосон тэтгэмжийн хэмжээ 1115.3 (5.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн даатгалын сангаас 2021 оны эхний 5 сард 455.0 мянган хүн тэтгэвэр авсны 76.0 хувь нь өндөр насны тэтгэвэр авагчид, 15.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр авагчид, 8.7 хувь нь бусад (тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэр) тэтгэвэр авагчид байна.

Зураг 2. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид, төрлөөр, 2021 оны эхний 5 сард



Нийгмийн халамжийн сангаас 2021 оны эхний 5 сард 2.3 (давхардсан тоогоор) сая хүнд 828.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 90.2(4.2%) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 352.7 (74.2%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Монгол Улсын Засгийн газраас иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр нийгмийн халамжийн сангаас олгож буй халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж 288.0 мянган төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн 100.0 мянган төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг шаардлагатай хүүхдэд 16.0 мянган төгрөг, насанд хүрэгчдэд 32.0 мянган төгрөгийг тус тус олгохоор шийдвэрлэсэн юм.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, тэдгээрт олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс нэмэгдэхэд “Хүүхдийн мөнгөн тэтгэмж” авсан 0-18 хүртэлх насны хүүхдийн тоо 60.9 (5.3%) мянгаар, олгосон тэтгэмжийн хэмжээ 330.4 тэрбум (2.2 дахин) төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 оны эхний 5 сард 57.1 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.3 (4.2%) мянган хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 22.2 (40.8%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн 67.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 25.8 хувь нь тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 6.5 хувь нь ахмад настан, 0.2 хувь нь 16 насанд хүрсэн одой иргэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 оны эхний 5 сард 104.4 мянган хүн хамрагдсаны 54.9 хувь нь асаргааны тэтгэмжид, 45.1 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 оны эхний 5 сард 41.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 5.7 (15.8%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

18 хүртэлх насны 1.2 сая хүүхдэд 602.9 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2021 оны эхний 5 сард олгожээ.

Хүснэгт 1. Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамрагдагчид, төрлөөр

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V	2020 I-V	2021 I-V	$\frac{2021 \text{ I-V}}{2020 \text{ I-V}}$
Бүгд	1 556 403	1 940 396	2 173 071	2 263 294	104.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	396 735	387 810	386 933	390 022	100.8
Тэтгэвэр	55 014	54 581	54 855	57 145	104.2
Тэтгэмж	52 410	85 438	89 177	104 399	117.1
Үйлчилгээ (халамжийн, хөгжлийн)	289 311	247 791	242 901	228 478	94.1
Эхийн алдар одонгийн мөнгөн урамшуулал	206 679	210 214	216 584	228 581	105.5
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	681 015	912 000	1 143 683	1 204 550	105.3
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	73 348	61 842	54 426	64 211	118.0
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	3 869	2 373	2 417	60	2.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	14 460	10 427	10 679	6 329	59.3
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	58 274	227 282	222 491	143 522	64.5
Насны хишиг	122 023	128 099	135 490	225 625	166.5
Цаатан иргэний тэтгэмж	-	349	368	394	107.1

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн

халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг **нийгмийн халамж** гэнэ.

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



Мэдээлэл авах линк:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 7 дугаар сарын 19

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас: (976-51)-264805*

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын
статистикч Э.Ариунчимэг
Утас: (976-51)-263966*